МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 06 өдөр Дугаар А/201 Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйл 30.2, 38 дугаар зүйл 38.1, 38.4 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Бага тойруу-1-119 тоот) байршилтай 671 м.кв (0,06 га) орон сууцны зориулалттай газрын эзэмшигч иргэн Норжмоогийн Мөнх-Очир (ЗЮ:73091878) нь 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нас барсан. Иймд эхнэр Маамын Нарангэрэл (ЗЗ:80111002)-д зориулалтаар шилжүүлж 20 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/09 тоот захирамжийн иргэн Н.Мөнх-Очир-т холбогдох хэсэг мөн газар эзэмших 000614665 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

4823100499